



- 3.12. Компанийн хувьцаа эзэмшигч нь шинээр нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах саналаа хуульд заасан журмын дагуу зар хүргэсэн өдрийн дараагийн өдрөөс эхлэн ажлын 30 өдрийн дотор компанид бичгээр ирүүлэх бөгөөд компанид саналаа өгсөн өдрөөс эхлэн 30 өдрийн дотор худалдан авах хувьцааны үнийг төлсөн баримтыг компанид ирүүлснээр тэргүүн ээлжинд хувьцааг худалдан авсанд тооцно. Хэрэв энэ хугацаанд төлбөрөө хийгээгүй буюу бусдад албан есоор шилжүүлснээ баримтаар нотолж компанид ирүүлээгүй бол тэргүүн ээлжинд худалдан авах эрх нь хүчингүй болж эдгээр хувьцааг бусдад чөлөөтэй худалдах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргаж худалдана.
- 3.13. Шинээр нэмж гаргаж байгаа хувьцааны төлбөрийг зөвхөн мөнгөн хэлбэрээр хийнэ.
- 3.14. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
- 3.15. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

### ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 4.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч мөн болно.
- 4.2. **Компанийн хувьцаа эзэмшигчийн эрх:**
  - 4.2.1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байгаа этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
  - 4.2.2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгохоор шийдвэрлэсэн хэмжээгээр эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа олгоогүй бол алданги төлөхийг шаардах;
  - 4.2.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
  - 4.2.4. Компанийн энгийн хувьцааны 75-ээс дээш хувийг нэг буюу нэгдмэл сонирхолтой хэсэг этгээд эзэмшсэн тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
  - 4.2.5. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах;
  - 4.2.6. Нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших энгийн хувьцаа, энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны тоог хязгаарлахгүй.
  - 4.2.7. Хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигч нарын саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах;
  - 4.2.8. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж дүрмийг шинэчлэн баталснаар зарим хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн, тэдгээр нь эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
  - 4.2.9. Компани нь хуульд заасан нөхцөлөөр өөрчлөн байгуулагдах тохиолдолд өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;



- 4.2.10. Их хэмжээний хэлцлийг баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
  - 4.2.11. Хууль, дүрэмд заасан бусад нөхцөл бүрдсэн тохиолдол бүрт хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
  - 4.2.12. Саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлд гаргах;
  - 4.2.13. Төлөөлөн удирдах зөвлөл энэ дүрмийн 4.2.12-т заасан хувьцаа эзэмшигчийн шаардлагын дагуу хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй тохиолдолд шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч ээлжит бус хурал хуралдуулах шийдвэрийг бие даан гаргах;
  - 4.2.14. Энэ дүрмийн 4.2.12-т заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаас татгалзсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах;
  - 4.2.15. Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах;
  - 4.2.16. Энгийн хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон Төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний тухай саналаа хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах санал гаргах;
  - 4.2.17. Компанийн тухай хуульд заасан компанийн дотоод мэдээлэлтэй танилцах;
  - 4.2.18. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах;
  - 4.2.19. Компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
  - 4.2.20. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
  - 4.2.21. Компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулахыг компаниас шаардах;
  - 4.2.22. Компанийн хувцаа эзэмшигч нь бусад компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтан байж болно.
- 4.3. Компанийн хувьцаа эзэмшигчийн үүрэг:**
- 4.3.1. Компанийн хувьцаа, бусад үнэт цаас эзэмшигч этгээд нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон эзэмшилд байгаа үнэт цаасны төрөл, тоог компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөгч албан тушаалтанд албан ёсоор мэдээлэх, эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэдэгдэх;
  - 4.3.2. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс хэмжээний хувьцааг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох;
  - 4.3.3. Компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа




- этгээд нь худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эцгийн ба өөрийн нэр, оршин суугаа хаяг, тус бүрийн эзмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдээллийг компани болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх;
- 4.3.4. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын 10 хоногийн дотор, тэдгээрийн хувьцаа таван хувиар нэмэгдэх тохиолдол бүрт тус тус компанид болон Санхүүгийн зохицуулах хороонд бичгээр мэдэгдэх;
- 4.3.5. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компани эргүүлж авахыг шаардах эрхийн дагуу худалдах болсон тохиолдолд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд түүнд овог, нэр, оршин суугаа бүртгэлтэй хаяг, эргүүлэн авахыг шаардаж байгаа хувьцааны тоог заасан байна. Ердийн журмаар худалдаж байгаа хувьцаа үүнд хамаарахгүй.
- 4.4. **Компанийн хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлага:**
- 4.4.1. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшсэн хувьцааныхаа тоо, тухайн үеийн зах зээлийн сүүлийн 6 сарын үнийн дундачаар үржүүлсэн нийт дүнгээр хариуцлага хүлээнэ.
- 4.4.2. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувь нийлүүлэгч өөрийн бүх хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.
- 4.4.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувь нийлүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

ТАВ. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС, ТҮҮНИЙГ ГАРГАХ,  
ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

- 5.1. Компани гаргасан энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад төрлийн үнэт цаас гаргаж болно.
- 5.2. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу бүртгүүлэх, нийтэд сурталчлах, андеррайтер болон зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг Гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.
- 5.3. Компанийн хувь нийлүүсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3 жил хүртэлх хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 5.6. Компанийн өөрийн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3-аас дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.7. Компанийн тодорхой тооны энгийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.



- 5.8. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
- 5.9. Хувьцаа, бусад үнэт цаасны үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.
- 5.10. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно.
- 5.11. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүйг авч болно.
- 5.12. Компаний нь энгийн хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар тэдний хувьцааг эргүүлэн авах тохиолдолд хяналтын багц хувьцааг эзэмшиж байгаа этгээдэд буюу нэгдмэл сонирхолтой хэсэг этгээдэд албан ёсоор тогтоосон зах зээлийн үнээс доошгүй үнээр худалдан авах зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 5.13. Компани дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно. Үүнд:
  - 5.13.1. Хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсан;
  - 5.13.2. Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа компани төлбөрийн чадвартай байх;
  - 5.13.3. Компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.



#### ЗУРГАА. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ

- 6.1. Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болно.
- 6.2. Хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох болон статистикийн бүртгэл хөтөлж холбогдох тайланг татварын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.
- 6.3. Компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх нэгж нь төгрөг байх бөгөөд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн орлого зарлага, өр, авлага зэрэг аливаа гүйлгээг төгрөгөөр бүртгэлд тусгана. Валютаар хийгдсэн ажил гүйлгээг төгрөгт шилжүүлэх бөгөөд тухайн өдрийн Монголбанкны албан ханшийг баримтална.
- 6.4. Компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтэд үндэслэн эрх бүхий татварын болон хөндлөнгийн хяналтын байгууллага шалгах эрхтэй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан холбогдох баримт, маягтыг шаардлагын дагуу танилцуулах үүрэг хүлээнэ.
- 6.5. Компани Монгол улсын аль нэг болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй байна.
- 6.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
  - 6.6.1. Гадаад, дотоодын банк, төрийн байгууллага, зээлдүүлэгчээс авсан зээл, зээлийн хүү, эрчим хүч, дулаан, ус сувгийн байгууллага болон тэдгээртэй адилтгах байгууллагуудад төлөх төлбөр, өрийг төлж дууссан байх;